



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.04.21 № 1219
танай _____-ны № _____-т

Хандивын тайлангийн дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Монголын ногоон намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

УИХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Монголын ногоон нам нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6, 26.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.7-д заасны дагуу Төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайд 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлангийн маягт, заавар”-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Төрийн аудитын дээд байгууллага нь Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.16-д заасны дагуу УИХ-ын ээлжит сонгуульд оролцох улс төрийн намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Тухайн намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулаагүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын дээд байгууллага хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын дээд байгууллага УИХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Монголын ногоон намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Төрийн аудит. Нийцлийн аудитын стандарт MNS 6817-8:2020, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/29 тоот тушаалаар батлагдсан “Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргах заавар”-ыг баримтлан Улс төрийн намын тухай хуулийн 18 дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих холбогдох нотлох баримтын үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.


Дүгнэлт

МОНГОЛЫН НОГООН НАМ нь 2020 оны ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэж тайлагнаагүй байна.

“Монголын ногоон нам”-аас ирүүлсэн хандивын тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 2 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ЗАНДАНБАТ